



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/47/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЭЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.22 № 53
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материалаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,566,039.19	43,411,981.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	1,604,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	1,604,000.00
31210	Төгрөг	0.00	1,604,000.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	1,604,000.00
33	АВЛАГА	0.00	30,764,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	30,764,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,566,039.19	11,043,981.87
35100	Түүхий эд материал	1,487,039.19	7,333,827.80
35130	Эм боох материал	1,487,039.19	7,333,827.80
35400	Хангамжийн материал	3,079,000.00	3,710,154.07
35420	Аж ахуйн материал	3,079,000.00	2,885,154.07
35460	Хүнсний материал	0.00	825,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	475,451,583.77	548,486,726.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	475,451,583.77	548,486,726.94
39200	Биет хөрөнгө	466,305,583.77	539,340,726.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	455,763,118.00	508,490,518.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-36,186,875.76	-49,049,132.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,346,940.00	50,610,506.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,724,197.23	-13,119,826.92
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	61,926,705.87	58,557,646.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,182,220.31	-21,888,607.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,592,075.40	13,937,651.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,243,962.20	-8,212,027.84
39217	Ном	14,000.00	14,000.00
39300	Биет бус хөрөнгө	9,146,000.00	9,146,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,146,000.00	9,146,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	480,017,622.96	591,898,708.81
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	480,017,622.96	591,898,708.81
51	Засгийн газрын хувь оролцоо	480,017,622.96	591,898,708.81
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	163,975,597.15	163,975,597.15
51200	Хуримтлагдсан үр дүн	104,917,509.01	216,798,594.86
51210	Өмнөх үеийн үр дүн	111,081,006.08	104,917,509.01
51220	Тайлант үеийн үр дүн		111,881,085.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	211,124,516.80	211,124,516.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	480,017,622.96	591,898,708.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	436,703,414.65	913,317,859.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,669,384.65	302,730,399.07
120	Нийтлэг татварын бус орлого	63,669,384.65	302,730,399.07
120009	Бусад орлого	2,167,563.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	25,999,606.00	107,404,015.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	35,502,215.65	195,326,383.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,034,030.00	610,587,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	332,880,200.00	378,982,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,880,200.00	378,982,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,943,350.00	196,875,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,943,350.00	166,111,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	30,764,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,944,600.00	9,098,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,944,600.00	9,098,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28,265,880.00	25,631,160.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,265,880.00	25,631,160.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	442,866,911.72	793,176,652.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,866,911.72	793,176,652.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,420,740.72	763,776,652.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,350,000.00	361,614,625.00
210101	Үндсэн цалин	168,500,000.00	168,500,000.00
210102	Нэмэгдэл	76,456,000.00	156,857,837.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	0.00
210104	Урамшуулал	16,850,000.00	25,353,688.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,903,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,092,300.00	40,908,700.00
210201	Тэтгэврийн даатгал	25,398,300.00	26,924,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,673,500.00	5,050,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,138,800.00	2,183,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	534,700.00	794,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,347,000.00	5,955,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,141,109.00	7,498,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,896,509.00	2,100,000.00
210302	Түлш, халаалт	4,094,600.00	5,248,900.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,400,620.00	30,638,788.00
210401	Бичиг хэрэг	1,943,100.00	2,679,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,692,700.00	20,944,318.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,163,300.00	1,929,800.00

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	378,140.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,301,520.00	4,707,030.00
2105	Нормативт зардал	55,427,626.46	283,068,446.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,777,626.46	262,429,526.03
210502	Хоол, хүнс	5,507,900.00	17,747,180.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,142,100.00	2,891,740.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,403,000.00	5,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	4,300,000.00
210604	Урсгал засвар	1,403,000.00	800,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,696,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,696,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,729,263.00	630,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,629,263.00	630,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,076,822.26	32,621,193.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,846,180.00	6,512,442.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,230,642.26	26,108,751.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	446,171.00	29,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	29,400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	446,171.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	446,171.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-6,163,497.07	120,141,206.29
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	8,260,120.44
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	8,260,120.44
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,163,497.07	111,881,085.85

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,975,597.15	211,124,516.80	104,917,509.01	480,017,622.96
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	163,975,597.15	211,124,516.80	104,917,509.01	480,017,622.96
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	163,975,597.15	211,124,516.80	104,917,509.01	480,017,622.96
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	111,881,085.85	111,881,085.85
5	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	163,975,597.15	211,124,516.80	216,798,594.86	591,898,708.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	373,034,030.00	579,823,460.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,034,030.00	579,823,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	332,880,200.00	378,982,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,880,200.00	378,982,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,943,350.00	166,111,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,943,350.00	166,111,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,944,600.00	9,098,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,944,600.00	9,098,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28,265,880.00	25,631,160.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,265,880.00	25,631,160.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	371,642,030.00	578,219,460.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371,642,030.00	578,219,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,195,859.00	548,819,460.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,350,000.00	362,320,825.00
210101	Үндсэн цалин	168,500,000.00	168,500,000.00
210102	Нэмэгдэл	76,456,000.00	160,524,525.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	0.00
210104	Урамшуулал	16,850,000.00	21,402,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	11,894,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,092,300.00	40,202,500.00
210201	Тэтгэврийн даатгал	25,398,300.00	28,290,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,673,500.00	2,978,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,138,800.00	2,382,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	534,700.00	595,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,347,000.00	5,955,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,141,109.00	7,498,900.00
210301	Гэрэл, цахилгаан	1,896,509.00	2,100,000.00
210302	Түлш, халаалт	4,094,600.00	5,248,900.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,215,700.00	28,404,800.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	2,975,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,508,900.00	17,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,929,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	1,300,000.00

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	4,300,000.00
2105	Нормативт зардал	21,782,450.00	94,596,435.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,132,450.00	74,365,435.00
210502	Хоол, хүнс	5,750,000.00	18,331,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,900,000.00	1,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	5,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,500,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00
2107	Томилот, зочны зардал	1,800,000.00	1,696,000.00
210702	Дотоод албан томилот	1,800,000.00	1,696,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,166,700.00	1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,066,700.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,047,600.00	8,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,047,600.00	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	446,171.00	29,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	29,400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	446,171.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	446,171.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,392,000.00	1,604,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,392,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,392,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,392,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,392,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,392,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	1,604,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,604,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,304,500.00	412,108,460.00	4,196,040.00	98.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,304,500.00	412,108,460.00	4,196,040.00	98.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,304,500.00	412,108,460.00	4,196,040.00	98.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,796,300.00	297,796,300.00		100
210101	Үндсэн цалин	168,500,000.00	168,500,000.00		100
210102	Нэмэгдэл	96,000,000.00	96,000,000.00		100
210104	Урамшуулал	21,402,000.00	21,402,000.00		100
210105	Гэрээт ажлын хөлс	11,894,300.00	11,894,300.00		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,202,500.00	40,202,500.00		100
210201	Тэтгэврийн даатгал	28,290,600.00	28,290,600.00		100
210202	Тэтгэмжийн даатгал	2,978,000.00	2,978,000.00		100
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,382,400.00	2,382,400.00		100
210204	Ажилгүйдлийн даатгал	595,600.00	595,600.00		100
210205	Эрүүл мэндийн даатгал	5,955,900.00	5,955,900.00		100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,498,900.00	7,498,900.00		100
210301	Гэрэл, цахилгаан	2,100,000.00	2,100,000.00		100
210302	Түлш, халаалт	5,248,900.00	5,248,900.00		100
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00		100
2104	Хангамж, бараа материалын зардал	22,906,800.00	22,906,800.00		100
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,800,000.00		100
210402	Тээвэр, шатахуун	15,200,000.00	15,200,000.00		100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,306,800.00	1,306,800.00		100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	1,300,000.00		100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	3,300,000.00		100
2105	Нормативт зардал	30,300,000.00	27,907,960.00	2,392,040.00	92.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,900,000.00	18,507,960.00	2,392,040.00	88.55
210502	Хоол, хүнс	7,500,000.00	7,500,000.00		100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,900,000.00	1,900,000.00		100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,100,000.00	5,100,000.00		100
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00		100
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00		100
2107	Томилолт, зочны зардал	3,300,000.00	1,696,000.00	1,604,000.00	51.39
210702	Дотоод албан томилолт	3,300,000.00	1,696,000.00	1,604,000.00	51.39
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	1,000,000.00	200,000.00	83.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00		100
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00		80,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00		120,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00		100

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	416,304,500.00	413,712,460.00	2,592,040.00	99.38
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	378,982,400.00	378,982,400.00		100
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	378,982,400.00	378,982,400.00		100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,098,900.00	9,098,900.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	9,098,900.00	9,098,900.00		100
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,223,200.00	25,631,160.00	2,592,040.00	90.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,223,200.00	25,631,160.00	2,592,040.00	90.82
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,604,000.00	1,604,000.00	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21		100
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	16	16		100
8	Үйлчлэх ажилтан	4	4		100
32	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	14	14		100
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7		100

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	166,111,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,111,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,711,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,524,525.00
210101	Үндсэн цалин	-
210102	Нэмэгдэл	64,524,525.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,498,000.00
210401	Бичиг хэрэг	1,175,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	623,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00
2105	Нормативт зардал	66,688,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,857,475.00
210502	Хоол, хүнс	10,831,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	166,111,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,111,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	166,111,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн болон эмнэлэгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЭЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “Ёс зүй, ажлын хариуцлагыг сайжруулах урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмжийг сайжруулах, эх хүүхдийн өвчин эндэгдлийг бууруулах, гамшгийн үед эмнэлэгийн бэлэн байдлыг хангах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268, А/387/99 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 416.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 73,0 сая төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Мөнгөн хөрөнгө	0	1.6	-1.6	
Авлага	0	30.7	-30.7	
Бараа материал	4.5	11.0	-6.5	(144.4)
Үндсэн хөрөнгө	475.5	548.5	-73	(15.4)
Нийт хөрөнгө	480.0	591.8	111.8	23.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	480.0	591.8	111.8	23.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	480.0	591.8	111.8	23.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 1.6 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 30.7 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байа.
- Бараа материал эхний үлдэгдлээс 6.5 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын данс нь 4.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 134.5 сая төгрөг, хандиваар 47.8 сая төгрөг, шилжүүлэн авсан 147.5 нийт 329.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 323.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 11.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 15.4 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 475.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд хандиваар 107.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 26.1 сая төгрөгийн элэгдэл, 8.3 сая төгрөгийн гарзаар тус тус буурч 548.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 111.8 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61.6	302.8	241.2
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	332.9	378.9	46.0
Нэмэлт санхүүжилт	3.9	196.9	193.0
Орон нутгийн төсвөөс	10.0	9.1	(0.9)
Эрүүл мэндийн даатгалын сангаас	28.3	25.6	(2.7)
Үйл ажиллагааны орлого	436.7	913.3	476.6
Цалин, шимтгэлийн зардал	303.4	402.5	99.1
Бараа ажил үйлчилгээний зардал	84.2	328.1	243.9
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12.7	0.6	(12.1)
Бараа үйлчилгээний бусад зардал	42.1	32.6	(9.5)
Урсгал шилжүүлэг	0.4	29.4	29.0
Хөрөнгийн зардал	-	-	-
Үйл ажиллагааны зардал	442.8	793.2	350.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6.1	111.8	117.9

Булган сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 476.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтыг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 456.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 39.9 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 416.3 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 416.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2.5 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу ирсэн байна. Тайлант онд 412.1 сая төгрөгийг зарцуулж, 1.6 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 136.7 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 29.4 сая төгрөг нийт 166.1 сая төгрөг ирсэн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан байна. Үүнд: цалин шимтгэлд 64.5 сая, бичиг хэрэгт 1.2 сая, тээвэр шатахуунд 2.7 сая, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1.0 сая, эмийн зардалд 55.9 сая, хоол хүнсэнд 10.8 сая, багаж, шуудан холбоонд 0.6 сая, мөнгөн тэтгэмжид 29.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Булган сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ үзүүлж ЭМДС-аас 196.8 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 166.1 сая төгрөг авч оны эцэст 30.7 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлж 1.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнасан бол ЭМГ-ын даргын 2021.08.25-ны өдрийн 02/849 дугаар тушаалын дагуу 7.3 сая төгрөгийн эмийн нөөцийг бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 29.4 сая төгрөг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 416.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 195.3 сая төгрөгийн бараа материал, 107.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Тус байгууллага нь үндсэн орон тооны жолоочтой бөгөөд цалингийн зардалд 18.0 сая төгрөг олгосон байна. Тайлант онд ЭМЯ-аас 34.0 сая төгрөгийн өртөгтэй УАЗ-фургон авто машин хандиваар ирснийг бүртгэл тайланд тусгасан бөгөөд шатахууны зардалд 17.9 сая төгрөг зарцуулсан байна. Харин өмнө нь ашиглагдаж байсан 29.7 сая төгрөгийн балансын үнэтэй УАЗ Фургон авто машиныг аймгийн ИТХ-ын 2021.04.16-ны өдрийн 13 дугаар тогтоолын дагуу Чулуут сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлсэн байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 88 мэдээллийг хугацаанд нь, 60 мэдээллийг хугацаа хоцроосон, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 5.9 сая төгрөгийн 4 тушаал, шийдвэрийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд дотоод хяналт болон элэгдлээр анхны өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 2 заалт зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ. Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн 3.4 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 4.1 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулга гараагүй болно.

4.2 Албан шаардлага

Тайлант онд Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсантай холбоотой нийт 3.4 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчиж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		1	3.4					1	3.4		
	дүн	1	3.4					1	3.4		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		1	0					1	0	0	0
	дүн										
	Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0	0	0